

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмсүгэй:

“м/харьяалах нутаг дэвсгэрийн төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангах.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3 дахь заалтын “төрийн” гэснийг “үндэсний” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.6.5 дугаар заалт нэмсүгэй:

“20.6.5.төрийн архив.”

**2 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “сан” гэсний дараа “,үндэсний төв” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “архивын байгууллагад” гэснийг “Үндэсний төв архивт” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.14 дэх заалтын “болон” гэсний дараа “Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

“5.Төрийн бус байгууллага нь албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан албан хэрэг хөтлөлт болон байгууллагын архивт баримтлах журмыг мөрдөнө.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “үндэсний төв архивын салбар” гэснийг “төрөлжсөн архив” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 2/Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийн “төрөлжсөн” гэснийг “тусгай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1998 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр баталсан Архивын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5.10 дахь заалт нэмсүгэй:

“15.5.10.архивын баримт түр хадгалах үйлчилгээ эрхлэх.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг